

“ЭРДЭНЭТ СУВАРГА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 3-р сарын 19-ны өдөр

№ 25/01

Булган хот

ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, 61.1.9 болон 63.5 дахь заалт, Тооллогын комиссын 1, 2, 3, 4 дүгээр саналын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компани нь 2024 оны ашгаас ноогдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.
3. Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ГАНТУЯА

ЭРДЭНЭТ СУВАРГА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 3-р сарын 19-ны өдөр

№ 25/02

Булган хот

ТУЗ-ийн гишүүдийг сонгох, урамшууллын дүнг батлах тухай.

Компанийн хуулийн 62.1.7 дах заалт болон Тооллогын комиссын 5, 6, 8, 9 дүгээр саналын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн ТУЗ болон хараат бус гишүүдийн дараах бүрэлдхүүнтэйгээр сонгосугай:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд:

1. Н. Одонбилэг
2. О. Маралмаа
3. Ж.Жадамба
4. Б.Батчимэг
5. Х.Гончигсүрэн
6. Л.Цангилагбар

ТУЗ-ын хараат бус гишүүдэд:

1. Л.Гантуяа
2. С.Энхтүвшин
3. Ц.Сайнжаргал

2. ТУЗ-ын болон Хараат бус гишүүдийн 2024 оны урамшууллын дүнг нэг гишүүний 350 000 /гурван зуун тавин мянган/ төгрөгөөр тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ГАНТУЯА

“ЭРДЭНЭТ СУВАРГА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03-р сарын 19-ны өдөр

№ 25/03

Булган хот

Компанийн хувьцааг хуваах, дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулахыг батлах тухай.

Компанийн хуулийн 51, 62 дугаар зүйл болон Тооллогын комиссын 7 дугаар саналын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Эрдэнэт суварга” ХК-ийн нийт гаргасан 156054 ширхэг энгийн хувьцааг нэг бүрийн 214 хувааж, нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 33 395 556 ширхэг энгийн хувьцаа болгон хуваасугай.
2. “Эрдэнэт суварга” ХК-ийн хувьцаа хуваах төслийг энэ тогтоолын 1-р хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан компанийн нэрлэсэн үнэ, тоо өөрчлөгдөх тул компанийн дүрмэнд нэмэлт өөрчлөлтийг оруулж, оруулсан өөрчлөлтийн дагуу холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, холбогдох зөвшөөрөл авах ажлыг зохион байгуулахыг гүйцэтгэх захирал /Н.Одонбилэг/-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ГАНТУЯА